



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 43

Улаанбаатар хот

Г “Цагдуултай” ХК-ийн үнэт цаасны бүртгэлд Г
өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 23.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.1.2, 34.1.1, “Цагдуултай” ХК-ийн 2013 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Цагдуултай” ХК-ийн оноосон нэрийг “Монголын хөгжил үндэсний нэгдэл” ХК болгон үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/-т, хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/-д, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлд өөрчлөлт оруулахыг “ҮЦГТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. “Цагдуултай” ХК-ийн үнэт цаасны бүрдүүлбэрт өөрчлөлт оруулахтай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг гүйцэтгэх захирал /Б.Ариунтөгс/-д үүрэг болгосугай:


1/ Энэхүү тогтоолын 1-т заасан оноосон нэрийн өөрчлөлтийг хуульд заасан журмын дагуу улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж, энэ тухай Хороонд мэдэгдэх;

2/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллах;

3/ Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 210 дугаар тогтоолоор батлагдсан “Монголын компанийн засаглалын кодекс”-ыг үйл ажиллагаандаа чанд баримталж, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалж ажиллах.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000033